



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР,
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТАЫН ГАЗАР, ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар A/235, A/02, A/128, A/34, A/198 Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийн 5.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын агаарын хаалгаар нэвтрэн орж ирсэн гадаадын болон Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг хилийн боомтгүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт тус тус даалгасугай.

ИРГЭНИЙ
НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

ХИЛ
ХАМГААЛАХ
ЕРӨНХИЙ
ГАЗРЫН
ДАРГА

МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ
ГАЗРЫН
ДАРГА


ГАДААДЫН
ИРГЭН,
ХАРЬЯАТАЫН
ГАЗРЫН
ДАРГА

ГААЛИЙН
ЕРӨНХИЙ
ГАЗРЫН
ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН Ц.СЭРГЭЛЭН Н.ЦАГААНХҮҮ

Д.МӨРӨН

Б.АСРАЛТ



Иргэний нисэхийн өрөнхий газар, Хил хамгаалах
өрөнхий газар, Мэргэжлийн хяналтын өрөнхий газар,
Гадаадын иргэн, харьяатын газар, Гаалийн өрөнхий
газрын даргын 2019 оны 09 дугаар сарын 04-ны өдрийн
A/335; A/02; A/08; A/336; A/08 дугаар хамгарсан
тушаалын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ХААЛГААР НЭВТРЭН ОРЖ ИРСЭН ГАДААДЫН
БОЛОН МОНГОЛ УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ АГААРЫН ХӨЛӨГ ХИЛИЙН БООМТГҮЙ
НИСЭХ БУУДАЛД АРГАГҮЙДСЭН БУУЛТ ҮЙЛДСЭН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ЖУРАМ**

АГУУЛГА

I.БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Нийтлэг үндэслэл
- 1.2 Эрх зүйн үндэслэл

**II.БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭ**

- 2.1 Мэдээлэл
- 2.2 Хэрэгжүүлэх арга хэмжээ

**III.БҮЛЭГ. ХИЛИЙН БООМТГҮЙ НИСЭХ БУУДАЛ БОЛОН НУТАГ ДЭВСГЭРИЙН
ЗАСАГ ЗАХИРГААНААС ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

- 3.1 Нисэх буудлын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллах
- 3.2 Хамтран ажиллах

**IV.БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭ**

- 4.1 Мэдээлэл
- 4.2 Хэрэгжүүлэх арга хэмжээ

V.БҮЛЭГ. ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1 Хэрэгжүүлэх арга хэмжээ
- 5.2 Хил хамгаалах байгууллага
- 5.3 Гадаадын иргэн харьяатын газар
- 5.4 Хилийн мэргэжлийн хяналтын байгууллага
- 5.5 Гаалийн байгууллагын үйл ажиллагаа

I. БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1.1. Энэхүү журам нь Монгол улсын агаарын хаалгаар нэвтрэн орж ирсэн гадаадын болон монгол улсын бүртгэлтэй агаарын хөлөг хилийн боомтгүй нисэх буудалд онцгой нөхцөл байдлын улмаас аргагүйдсэн буулт үйлдсэн тохиолдолд иргэний нисэхийн үйл ажиллагаа, улсын хилийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажиллах байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалт, харилцан ажиллагааг тогтооход чиглэнэ.
- 1.1.2. Улсын болон иргэний агаарын хөлөг олон улсын хилийн боомтгүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн тохиолдолд ажиллах үйл ажиллагаа нь Монгол Улсын холбогдох хуулиуд болон Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолоор баталсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”, зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд олон улсын хилийн боомтгүй нисэх буудалд агаарын хөлөг, зорчигчийг нэвтрүүлэхэд нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын бэлэн байдлыг хангах, улсын хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах замаар хэрэгжинэ.
- 1.1.3. Улсын болон иргэний агаарын хөлөг олон улсын хилийн боомтгүй нисэх буудалд онцгой нөхцөл байдлын улмаас аргагүйдсэн буулт үйлдсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн нисэх буудлын дарга удирдан зохицуулна.
- 1.1.4. Хилийн хяналтын үйл ажиллагааг “Хилийн хяналтын шуурхай бүлэг” гүйцэтгэнэ.
- 1.1.5. Хилийн хяналтын шуурхай бүлэгт энэхүү журмаар үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа байгууллагуудаас томилогдсон бүрэлдэхүүн ажиллана.
- 1.1.6. Тухайн агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх нисэх буудлын оршин буй нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллага нь гол унтраах, эрэн хайх, авран туслах, эмнэлгийн түргэн тусlamж үзүүлэх анги, хэсгүүдийн бэлэн байдлыг хангаж, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалт авч, шуурхай удирдлагаар хангаж ажиллана.
- 1.1.7. Энэхүү журмыг Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нар хамтран батална.

1.2 ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1.2.1 Журамд хамаарах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенци:

- Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенци;
- Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай 1973 оны Киотогийн конвенци;
- Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенци;
- Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенци, 1982 оны Женевийн конвенци;
- Базелийн конвенци; /Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэн зайлзуулахад хяналт тавих/
- Олон улсын эрүүл мэндийн дүрэм 2005.

1.2.2 Журамд хамаарах хуулиуд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;

- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль
- Монгол Улсын хилийн тухай хууль;
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;
- Гаалийн тухай хууль;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Хүн худалдаалахтай тэмцэх хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргэээр зорчих, цагаачлах тухай хууль;
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- Эрүүл ахуйн тухай хууль;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;
- Мансууруулах эм, сэтгэцэд нэлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль;
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Гамшигаас хамгаалах тухай хууль;
- Галын аюулгүй байдлын тухай хууль;
- Улсын нисэхийн тухай хууль;
- Бусад.

II.БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1 МЭДЭЭЛЭЛ

- 2.1.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага нь Иргэний нисэхийн дүрэм 12 /Осол зөрчлийн талаар мэдээлэх/, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны А/297 дугаар тушаалаар баталсан “Нислэгийн онцгой нөхцөл, байдал болон осол зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах, дамжуулах журам”-ын дагуу ажиллана.
- 2.1.2. Хилийн боомтгүй нисэх буудлын нислэгийн удирдагч нь агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх болсон шалтгаан, нөхцөл байдлын талаарх мэдээллийг Хавсралт 1-д заасны дагуу дамжуулна.

2.2 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 2.2.1 Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсад байнгын ажиллагаатай олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын талаарх мэдээллийг “Нисэхийн мэдээллийн эмхтгэл”-д тогтмол шинэчлэн тусгаж, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана.
- 2.2.2 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага нь аргагүйдсэн буулт үйлдэх агаарын хөлгийн тухай мэдээллийг нэгтгэн авч, үүссэн нөхцөл байдлыг үнэлэх, авах арга хэмжээний талаар санал боловсруулж, шуурхай арга хэмжээ авч ажиллана.
- 2.2.3 Улсын болон иргэний агаарын хөлөг хилийн боомтгүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн тохиолдолд хөрш орнуудтай байгуулсан нисэхийн эрэн хайх, авран туслах хэлэлцээрийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

- 2.2.4 Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн хяналтын байгууллагуудтай “Хамтран ажиллах төлөвлөгөө”-ний дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.2.5 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь агаарын хөлөг хилийн боомтгүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдэх болсон шалтгаан, нисэх баг, зорчигч, шатахууны үлдэгдэл, ачааны талаарх мэдээллийг хилийн хяналтын төв байгууллагуудад шуурхай мэдээлнэ.

III.БҮЛЭГ. ХИЛИЙН БООМТГҮЙ НИСЭХ БУУДАЛ БОЛОН ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1 НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ

- 3.1.1 Тухайн нисэх буудлын дарга нь нислэгийн удирдагчаас мэдээлэл авмагц Хавсралт 1-д заасан бүдүүвчийн дагуу зохих байгууллага болон удирдах албан тушаалтанд шуурхай мэдээлж, бий болсон нөхцөл байдалд үнэлэлт өгч, олон улсын нислэгийг хүлээн авах ажлыг шуурхай удирдлагаар ханган, зохион байгуулж ажиллана.
- 3.1.2 Хилийн боомтгүй нисэх буудалд агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх зурвасыг чөлөөлөх, зогсоол талбайг бэлтгэх, агаарын хөлгийн баг, зорчигчийг түр хугацаагаар байрлуулах, хилийн хяналт шалгалтын бүсийн талбайг бэлтгэх зэрэг үйл ажиллагааг нисэх буудлын дарга шуурхай зохион байгуулна.
- 3.1.3 Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зорчигч тээвэрлэж ирсэн агаарын тээвэрлэгч байгууллага тухайн зорчигчийг буцаан тээвэрлэх хүртэл нисэх буудал нь түр saatuuлах байраар хангаж ажиллана.
- 3.1.4 Тус бүс нутгийн хилийн хяналтын байгууллагуудыг үндсэн чиг үүргийнх нь дагуу үйл ажиллагаа явуулах бололцоогоор хангана.
- 3.1.5 Хилийн боомтгүй нисэх буудалд агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх тохиолдолд тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт байршдаг болон томилогдон очсон хилийн хяналтын байгууллагуудтай хамтран хилийн хяналт шалгалтын түр бүсийг тогтоон хамтран ажиллана.

3.2 ХАМТРАН АЖИЛЛАХ

- 3.2.1 Хилийн боомтгүй нисэх буудал нь тус журмын дагуу ойролцоо хил хамгаалах болон тухайн орон нутаг дахь хилийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах хэлцлийг урьдчилан байгуулна. /Хавсралт 2/
- 3.2.2 Хилийн хяналтын байгууллагууд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах хилийн боомтгүй нисэх буудалд гадаадын болон монгол улсын бүртгэлтэй агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой тусгасан заавар, төлөвлөгөө боловсруулсан байна. /нисэх буудлын "Онцгой байдлын төлөвлөгөө"-нд нэмэлт заалт тусган оруулж болно/
- 3.2.3 Хилийн хяналтын байгууллагууд тухайн нисэх буудалд очих хугацаа, тээврийн хэрэгслийн зардал болон аль байгууллага хариуцах талаар “Хамтран ажиллах төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлнэ.
- 3.2.4 Агаарын хөлөг нь аргагүйдсэн буулт үйлдсэний дараа 6 цагийн дотор нислэгээ үргэлжлүүлэх боломжтой тохиолдолд, мөн 6 цагаас дээш хугацаагаар саатах буюу нислэгээ цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон үед авах арга хэмжээний зохицуулалтыг нисэх буудал болон хилийн хяналтын байгууллагууд “Хамтран ажиллах төлөвлөгөө”-нд тусгасан байна. Үүнд:

- Тухайн нисэх буудал нь нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах үүднээс агаарын хөлгөөс ачаа, тээшийг буулгах шаардлагатай тохиолдолд бичиг баримтын бурдуулэлт хийх хүртэлх хугацаанд тэдгээрийг хадгалах байр буюу өрөөгөөр хангах;
- Нисэх буудал нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран ачаа, шууданг /бүхэлд нь буюу зарим хэсгийг/ тухайн агаарын хөлгөөр үргэлжлүүлэн тээвэрлэх боломжгүй тохиолдолд эцсийн цэг хүртэл газраар тээвэрлэх арга хэмжээг яаралтай зохион байгуулах;
- Шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийн баг, зорчигчийг түр хугацаагаар байрлуулах шаардлага хангасан байр, танхимаар хангах арга хэмжээг нисэх буудал нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Дэлхийн шуудангийн холбооны хамгаалалтын актын шаардлагын дагуу шууданг хадгалах бололцоогоор хангах;
- Агаарын хөлөгт аргагүйдсэн буулт үйлдсэн хилийн боомтгүй нисэх буудал нь нисэхийн аюулгүй байдлыг хангах бөгөөд хилийн хяналтын байгууллагууд нь үзлэг шалгалтыг хялбаршуулсан байдлаар гүйцэтгэх; /агаарын хөлөг болон холбогдох бичиг баримтаас General declaration шалгах, агаарын хөлгийн баг, зорчигч тэдгээрийн тээш зэргийг хялбаршуулсан байдлаар/

IV.БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

4.1 МЭДЭЭЛЭЛ

- 4.1.1. Агаарын хөлгийн дарга нь тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч, аргагүйдсэн буулт үйлдэх нисэх буудлын нислэгийн удирдагчаас дэмжлэг авна.
- 4.1.2. Нисэх баг нь хилийн боомтгүй нисэх буудлын нислэгийн удирдагчид буулт үйлдэх болсон шалтгаан, нөхцөл байдлын талаарх мэдээллийг өгнө.
- 4.1.3. Агаарын тээвэрлэгч байгууллага нь тухайн нислэгээр зорчиж буй зорчигчид болон онцгой анхаарал шаардлагатай зорчигчийн мэдээлэл, тээвэрлэж буй ачаа, агаарын хөлөгт гарсан техникийн саатал, гэмтлийн талаар нислэгийн удирдагчид тодорхой мэдээлнэ.
- 4.1.4. Агаарын тээвэрлэгч байгууллага нь агаарын хөлгийн хөөрч буух цаг, зорчигчдын талаарх мэдээлэл, нислэгийн баримт бичгүүд болон бусад шаардлагатай мэдээллүүдээр Иргэний нисэхийн ерөнхий газар болон хилийн хяналтын байгууллагуудыг хангана.
- 4.1.5. Нислэгийн үед халдварт өвчинтэй болон халдварт өвчинтэй байж болзошгүй зорчигч илэрсэн тохиолдолд тухайн зорчигч болон илэрч буй өвчиний шинж тэмдгийн талаар аргагүйдсэн буулт үйлдэх нисэх буудалд урьдчилан мэдэгдэнэ.
- 4.1.6. Нислэгийн үед агаарын хөлөгт хууль тогтоомж зөрчсөн болон агаарын хөлгийн хэвийн ажиллагааг алдагдуулж буй “хэв журам зөрчсөн зорчигч”-ийн талаар аргагүйдсэн буулт үйлдэх нисэх буудалд урьдчилан мэдэгдэнэ.

4.2 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 4.2.1 Агаарын тээвэрлэгч Монгол Улсын хилээр нэвтрэхийг хориглосон зорчигч тээвэрлэж ирсэн тохиолдолд тухайн зорчигчийг хүлээн зөвшөөрөх улсруу буцаан тээвэрлэх арга хэмжээг зохион байгуулна.

- 4.2.2 Агаарын тээвэрлэгч байгууллага аргагүйдсэн буулт үйлдсэн агаарын хөлгийн зорчигчдын хоол, зочид буудлын төлбөр болон нисэх буудлын хураамжтай холбоотой зардлыг хариуцна.
- 4.2.3 Тухайн олон улсын хилийн боомтгүй нисэх буудал болон хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

У БҮЛЭГ. ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 5.1.1 Хилийн хяналтын байгууллагууд хамтран хилийн боомтгүй нисэх буудалд хяналт шалгалтын бүс тогтоох ажиллагааг зохион байгуулна.
- 5.1.2 Хилийн хяналтын байгууллагууд нь хилийн боомтгүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн улсын болон иргэний агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигчдын улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон хилийн хяналт шалгалтыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 5.1.3 Хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалттай холбогдсон шаардлагууд нь гадаадын агаарын хөлгийн нисэх багийн бүрэлдэхүүнд мөн адил хамаарна.
- 5.1.4 Хилийн хяналтын байгууллагууд нь хилийн хяналт шалгалтыг зохион байгуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

5.2 ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГА

- 5.2.1 Агаарын хөлгийн нисэх багийн гишүүд болон зорчигчдын хил нэвтрэх эрхийн баримт бичгийн шалгалтыг хялбарчилсан журмаар зохион байгуулж ажиллана.
- 5.2.2 Агаарын хөлгийн нисэх багийн гишүүд болон зорчигч тус бүрээр хилийн орох гарах хуудас бичүүлж, хил нэвтрэх эрхийн баримт бичгийг хуулбарлан авна.
- 5.2.3 Мэдээллийн нэгдсэн санд бүртгэх боломжгүй тохиолдолд 24 цагийн дотор нөхөн бүртгэж, зорчих эрхийг нь түр хугацаагаар хязгаарласан болон тус улсад орохыг хориглосон иргэдийн жагсаалттай тулгана.
- 5.2.4 Нөхөн бүртгэх явцад илэрсэн зөрчлийг шийдвэрлэх асуудлаар агаарын тээвэрлэгч байгууллагатай хамтран ажиллана.
- 5.2.5 Техникийн шалтгаанаар нисэх боломжгүй болсон агаарын хөлгийг засварлах зорилгоор ирсэн техникийн ажилтнуудыг түр нэвтрүүлэх арга хэмжээг саадгүй авч ажиллана.
- 5.2.6 Дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно. Үүнд:
 - Хил нэвтрэх эрхийн бичиг баримт хүчин төгөлдөр байх нөхцөл алдагдсан;
 - Хил нэвтрэх эрхийн бичиг баримт нь хуурамч буюу засвар, өөрчлөлт хийгдсэн;
 - Бусдын бичиг баримт ашигласан;
 - Хилийн шалгалтад орохос татгалзсан;
 - Хууль, тогтоомжийн дагуу Монгол Улсын хил нэвтрэх эрхийг нь хориглосон.

5.3 ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТАЫН ГАЗАР

- 5.3.1 Монгол Улсад визгүй зорчих баримт бичиг эзэмшигчдээс бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн визтэй зорчино.
- 5.3.2 Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан Монгол Улсын виз олгох эрх бүхий байгууллагаас визийн зөвшөөрөл авсан эсхүл тухайн

ангиллын виз олгоход шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг биедээ авч яваа гадаадын иргэнд зохиц ангиллын орох, дамжин өнгөрөх визийг олгож болно.

- 5.3.3 Тухайн агаарын хөлгийн зорчигчдын дунд Монгол Улсын хилээр нэвтрэхийг хориглосон гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд нэн даруй хил хамгаалах байгууллагад шилжүүлнэ.

5.4 ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА

- 5.4.1 Зорчигчдод тавих эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагуудыг ханган ажиллана.
- 5.4.2 Шаардлагатай тохиолдолд хилийн хяналтын байгууллага, нисэх буудал, агаарын тээвэрлэгчийн ажилтан, зорчигчдод урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлыг зохион байгуулж, холбогдох гэрчилгээ олгоно.
- 5.4.3 Нисэх багийн бүх гишүүд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнүүдэд хамрагдаж, халдварт өвчинээс урьдчилан сэргийлэх вакцин тариулсан гэрчилгээтэй эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 5.4.4 Халдвартын голомттой бүс нутгаас ирж, улсын хилээр нэвтэрч буй бүх зорчигчдоор эрүүл мэндийн тодорхойлолтын хуудас беглэсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 5.4.5 Халдварт өвчинтэй болон өвчинтэй байж болзошгүй зорчигч илэрсэн үед тухайн нисэх буудалд халдварт эсэргүүцэх арга хэмжээг удирдан зохион байгуулж ажиллана.
- 5.4.6 Халдварт өвчинтэй байж болзошгүй нисэх буудлын ажилтан болон зорчигч, мал амьтанд халдварт эсэргүүцэх анхан шатны үйлчилгээ, тусlamж үзүүлэн мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.
- 5.4.7 Халдварт хамгааллын дэглэмд нийцсэн тусгаарлах байр үзлэгийн өрөөг нисэх буудалд байгуулах асуудлыг нисэх буудлын захиргаанд тавьж, шийдвэрлүүлнэ.
- 5.4.8 Халдварт өвчинтэй байж болзошгүй зорчигчийг тусгаарласны дараа холбогдох эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, хорио цээр тогтоож, дуудлага өгнө.
- 5.4.9 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр тодорхойлсон халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, тээвэрлэгдэн ирсэн ачаа тээш, бараа бүтээгдэхүүнд байж болзошгүй нян, вирусийг гадаад орчинд тараахгүй, устгах зорилгоор агаарын хөлөгт ариутгал халдвартайжилтийг хийнэ.
- 5.4.10 Зорчигчийн ачаа, тээш, бараа бүтээгдэхүүнд мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт хийнэ.


5.5 ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.5.1 Зорчигч, тэдгээрийн гар тээш, ачаа, шууданг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх эсэх арга хэмжээг зохион байгуулна.
- 5.5.2 Агаарын хөлөг буулт үйлдсэн тохиолдолд агаарын хөлгөөс 30 метрийн радиус дахь талбай, хүлээлгийн танхим, зорчигчдын нэвтрэх болон ачаа тээшний хэсэг, эсхүл нисэх буудлыг гаалийн хяналтын түр бүсээр тогтоож, холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллана.
- 5.5.3 Гаалийн байгууллага нь зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэхдээ гаалийн хяналтын улаан, ногоон гарцаыг хэрэглэж болно.
- 5.5.4 Зорчигч, тэдгээрийн гар тээш, ачаа, шуудан болон бусад ачааг гаалийн хилээр нэвтрүүлэх бол холбогдох хууль болон гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмаар зохицуулна.
- 5.5.5 Зорчигч гаалийн хилийн ногоон гарцаар нэвтэрч байгаа тохиолдолд зорчигчийн гаалийн мэдүүлэг бичихгүй байж болно.

- 5.5.6 Ногоон гарцаар нэвтэрч буй зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, эмэнд гаалийн хяналт тавьж, улсын хилээр нэвтрүүлнэ.
- 5.5.7 Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, эмийг “Гаалийн тухай хуулийн 226, 227, 230 дугаар зүйл”-д заасан зөвшөөрөгдөх тоо хэмжээгээр улсын хилээр нэвтрүүлнэ.

---oOo---

“Монгол улсын агаарын хаалгаар нэвтрэн орж ирсэн гадаадын болон Монгол улсын буртгэлтэй агаарын хөлөг хилийн боомтгүй нисэх буудалд аргатгыйдсэн буулт үйлдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн журам”-ын мэдээлэл дамжуулах буудувч



Хэлцлийн загвар

“ НИСЭХ БУУДАЛ

ОНЫ -Р САРЫН -НЫ ӨДӨР

ДУГААР: №

ХАМТРАН АЖИЛЛАХ ХЭЛЦЭЛ

“МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ХААЛГААР НЭВТРЭН ОРЖ ИРСЭН ГАДААДЫН БОЛОН МОНГОЛ УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ АГААРЫН ХӨЛӨГ ХИЛИЙН БООМТГҮЙ НИСЭХ БУУДАЛД АРГАГҮЙДСЭН БУУЛТ ҮЙЛДСЭН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ЖУРАМ”-ыг хүлээн зөвшөөрч, энэхүү журамд заагдсан холбогдох үүрэг хариуцлагын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрнө.

—
(ГАРЫН ҮСЭГ)

ОВОГ НЭР:

ОВОГ НЭР:

АЛБАН ТУШААЛ:

АЛБАН ТУШААЛ:

БАЙГУУЛЛАГА:

БАЙГУУЛЛАГА:

ХАЯГ:

ХАЯГ:

Орон нутгийн нисэх буудлуудын холбоо барих утасны жагсаалт

№	Нисэх буудал	Албан утас
1	Баян-Өлгий, "Өлгий" нисэх буудал	70422056
2	"Баянхонгор" нисэх буудал	70442667
3	"Булган" нисэх буудал	70342252
4	Говь-Алтай, "Алтай" нисэх буудал	70484044
5	Дорнод, "Чойбалсан" нисэх буудал	70584868
6	Дундговь, "Мандалговь" нисэх буудал	70592269
7	Завхан, "Доной" нисэх буудал	286138
8	Сүхбаатар, "Баруун Урт" нисэх буудал	70518259
9	Өвөрхангай, "Арвайхээр" нисэх буудал	70322769
10	Өвөрхангай, "Хархорин" нисэх буудал	286157
11	Өмнөговь, "Гурван сайхан" нисэх буудал	70533190
12	Завхан, "Тосонцэнгэл" нисэх буудал	281186
13	Увс, "Дэглий цагаан" нисэх буудал	70452550
14	"Ховд" нисэх буудал	70432518
15	Ховд, "Булган" нисэх буудал	286156
16	Хөвсгөл, "Мөрөн" нисэх буудал	70382002
17	Хөвсгөл, "Хатгал" нисэх буудал	98446899
18	Хэнтий, "Өндөрхаан" нисэх буудал	70562524
19	"Овоот" нисэх буудал	70070710
20	"Ханбумбат" нисэх буудал	286136
21	"Тавантолгой" нисэх буудал	70122279